



## ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**НАМ, ЭВСЭЛ, НЭР ДЭВШИГЧИЙН СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН САНХҮҮЖИЛТ,  
ТҮҮНИЙ ЗАРЦУУЛАЛТ, ГҮЙЦЭТГЭЛД ДҮГНЭЛТ ГАРГАХ, НИЙТЭД МЭДЭЭЛЭХ**

**Аудитын код: ДГА-2025/64-ШТА-НА**

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>	Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 70522734 Цахим хаяг: <a href="mailto:gan-ulzii.t@audit.gov.mn">gan-ulzii.t@audit.gov.mn</a>
Сайншанд 2025 он	Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 70503020 Цахим хаяг: <a href="mailto:oyuntulkhuur.u@audit.gov.mn">oyuntulkhuur.u@audit.gov.mn</a>
	Аудитор: Н.Түвшинбаатар Г.Мөнх-Оргил Утас: 70523020 Цахим хаяг: <a href="mailto:tuvshinbaatarn@audit.gov.mn">tuvshinbaatarn@audit.gov.mn</a>

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

Товчилсон үгийн тайлбар .....	3
Хүснэгтийн товъёог .....	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл .....	5-6
<b>БҮЛЭГ 1. НАМ, НЭР ДЭВШИГЧ НЬ ХУУЛЬД ЗААСНЫ ДАГУУ МӨНГӨН ХАНДИВЫГ БҮРДҮҮЛСЭН БАЙНА.....</b>	<b>7</b>
1.1. Нам, нэр дэвшигчдийн сонгуульд зарцуулах мөнгөн хандивыг хуульд заасан хэмжээнд бүрдүүлсэн байна. ....	7
1.2. Нам, нэр дэвшигчид хуулиар зөвшөөрөгдөөгүй 1,101.0 мянган төгрөгийн хандивыг буцаан шилжүүлээгүй, сонгуулийн үйл ажиллагаанд зарцуулсан байна. ....	7
<b>БҮЛЭГ 2. НАМ, НЭР ДЭВШИГЧ НЬ БҮРДҮҮЛСЭН ХӨРӨНГИЙГ ЗАРЦУУЛААГҮЙ БАЙНА.</b>	
2.1. Бүрдүүлсэн хандив болон хөрөнгийг зарцуулаагүй байна.....	8
2.2. Сонгуулийн сурталчилгааны зардалд хөрөнгө зарцуулаагүй байна.....	8
2.3. Төрийн аудитын газраас тогтоосон зардлын дээд хэмжээг баримталж ажилласан байна.....	9
Дүгнэлт .....	10

## Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын Олон Улсын стандарт
АНСДИТХСТ	Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай
АСХ	Аймгийн сонгуулийн хороо
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТАГ	Төрийн аудитын газар
ХАК	Хувийн аудитын компани

**Хүснэгтийн товъёог:**

<b>№</b>	<b>Тайлбар</b>	<b>Хуудасны дугаар</b>
<i>Хүснэгт 1</i>	<i>Нам, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын санхүүжилт, мянган төгрөг</i>	7
<i>Хүснэгт 2</i>	<i>Хандивлагчийн нэр, бүртгэлийн дугаар, эх үүсвэр тодорхойгүй хандивын зарцуулалт</i>	8
<i>Хүснэгт 3</i>	<i>Нам, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын ангилал</i>	9
<i>Хүснэгт 4</i>	<i>Татвар суутгаагүй олгосон зардлын хэмжээ</i>	10

## **Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл**

### **Аудит хийх үндэслэл, бүрэн эрх**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, АНСДИТХСТ хуулийн 57 дугаар зүйл, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2025 гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэв.

### **Аудитын зорилт**

Нам, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын санхүүжилт, түүний зарцуулалтын тайланг хянаж, нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлэхэд оршино.

Аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэлээ. Үүнд:

1. Нам, нэр дэвшигч нь сонгуульд зарцуулах хөрөнгийн санхүүжилтийг хуулийн дагуу бүрдүүлсэн эсэх
2. Хөрөнгийг хууль журамд заасны дагуу зарцуулсан эсэх

### **Аудитын хамарсан хүрээ**

Аудитад Айраг, Дэлгэрэх, Сайхандулаан сумдын ИТХ-ын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчийг хамрууллаа.

### **Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, АДБОУС 400, АДБОУС 4000 дугаар стандартууд, Монгол Улсын Төрийн аудитын стандарт-Нийцлийн аудит MNS 6817-6:2020, МУЕА-ын 2021 оны А/71 тушаалаар батлагдсан “Нийцлийн аудитын аргачлал”, А/69 тушаалаар батлагдсан “Гүйцэтгэлийн аудитын аргачлал”-ыг баримтлан сонгуулийн зардлын тайлангийн талаар нам, нэр дэвшигч, ХАК-ний холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, ХАК-ний гаргасан дүгнэлтийн мэдээллийг нэгтгэх, хандив өгсөн иргэн, аж ахуйн нэгжийн талаарх тодруулгыг УБХ-ээс авах, тайлан, судалгаа, баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийн аудитын судалгаа, хөтөлбөр, арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулах дүгнэлт боловсруулж, нийтэд мэдээллээ.

Дараах хууль эрх зүйн актыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль,
- АНСДИТХСТ хууль,
- Дээрх хуулиудтай нийцүүлэн гаргасан тогтоол, журам.

**Аудитын  
бүрэлдэхүүн,  
хугацаа**

Аудитыг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Т.Ган-Өлзий удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер У.Оюунтүлхүүр хэрэгжүүлж, аудитор Н.Түвшинбаатар, Г.Мөнх-Оргил нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв.

Аудитыг 2025 оны 8 дугаар сарын 25-ний өдрөөс 2025 оны 9 дүгээр сарын 01-ны өдрийн хооронд хэрэгжүүлж, дүнг нийтэд мэдээлэх

## ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:

Айраг, Дэлгэрэх, Сайхандулаан сумдын ИТХ-ын 2025 оны нөхөн сонгуульд 2 намаас 6 нэр дэвшигч оролцсон байна.

АНСДИТХСТ хуулийн 56 дугаар зүйлийн 56.3-т “Нам, эвсэл нь санал авах өдрөөс хойш 45 хоногт, нэр дэвшигч санал авах өдрөөс хойш 30 хоногт багтаан зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ” гэж заасны дагуу сонгуулийн зардлын тайлангаа аудитын хуулийн этгээдээр баталгаажуулан Төрийн аудитын байгууллагад 2 нам, 6 нэр дэвшигч зардлын тайлан ирүүлсэн байна.

АНСДИТХСТ хуулийн 56 дугаар зүйлийн 56.5-т заасны дагуу нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын дансны хуулгыг хуулийн хугацаанд харилцагч банкнууд бүрэн ирүүлсэн байна.

## БҮЛЭГ 1. НАМ, НЭР ДЭВШИГЧ НЬ ХУУЛЬД ЗААСНЫ ДАГУУ МӨНГӨН ХАНДИВЫГ БҮРДҮҮЛСЭН БАЙНА.

**1.1 Нам, нэр дэвшигчдийн сонгуульд зарцуулах мөнгөн хандивыг хуульд заасан хэмжээнд бүрдүүлсэн байна.**

АНСДИТХСТ хуулийн 53 дугаар зүйлийн 53.1-т “мөнгөн хандив иргэний хувьд хоёр сая төгрөг хүртэл, хуулийн этгээдийн хувьд 10 сая төгрөг хүртэл байна”, 53.2-т “иргэн, хуулийн этгээдээс нам, эвсэлд эсхүл нэр дэвшигчид зардлын данс нээсэн өдрөөс хойш сонгуулийн үйл ажиллагаанд нь зориулан энэ хуулийн 53.1-д заасан хэмжээнээс хэтрүүлэхгүйгээр хандив өгч болно” гэж заасан байна.

Орон нутгийн нөхөн сонгуульд Ардчилсан намд 1 иргэнээс 1,000.0 мянган төгрөг, Ардчилсан намын 1 нэр дэвшигчид 1 иргэнээс 100.0 мянган төгрөг, Монгол Ардын намын 3 нэр дэвшигчид 13 иргэнээс 8,093.0 мянган төгрөгийг хандивласан байна.

Хүснэгт №1. Нам, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын санхүүжилт

(мянган төгрөгөөр)

№	Нам, нэр дэвшигч	Орлогын ангилал						Нийт мөнгөн дүн
		Мөнгөн хандив				Мөнгөн бус хандив		
		Нам, нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө		Иргэн				
тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн			
1	Айраг сумын Монгол Ардын намаас нэр дэвшигч	-	-	10	5,002.0	-	-	5,002.00
2	Дэлгэрэх сумын Монгол Ардын намаас нэр дэвшигч	-	-	1	1,995.0	-	-	1,995.00
3	Сайхандулаан сумын Монгол Ардын намаас нэр дэвшигч	1.0	0.30	2	1,096.0	-	-	1,096.30
4	Айраг сумын Ардчилсан нам	-	-	1	1,000.0	-	-	1,000.00
5	Айраг сумын Ардчилсан намаас нэр дэвшигч	1.0	0.85	1	100.0	-	-	100.85

	<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>1.15</b>	<b>15</b>	<b>9,193.00</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>9,194.15</b>
--	-----------------	----------	-------------	-----------	-----------------	----------	----------	-----------------

Эх үүсвэр: Нам, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайлан

Харин эдгээр нам, нэр дэвшигчдэд хуулийн этгээдээс хандив өгөөгүй байна.

**1.2 Нам, нэр дэвшигчид хуулиар зөвшөөрөгдөөгүй 1,101.0 мянган төгрөгийн хандивыг буцаан шилжүүлээгүй, сонгуулийн үйл ажиллагаанд зарцуулсан байна.**

АНСДИТХСТ хуулийн 53 дугаар зүйлийн 53.4-т “хандив өгч байгаа иргэн, хуулийн этгээд нь нэр, иргэний бүртгэлийн дугаар болон хандивын эх үүсвэрийн талаарх мэдээллээ банкны гүйлгээний баримтад тусгах бөгөөд энэ шаардлагыг хангаагүй хандивыг хандив хүлээн авагч буцаан шилжүүлнэ” гэж заасан байна.

Орон нутгийн нөхөн сонгуульд Сайхандулаан сумын МАН-ын нэр дэвшигч нь 2 иргэнээс ирүүлсэн нийт 1,001.0 мянган төгрөгийн эх үүсвэр тодорхойгүй хандивыг буцаан шилжүүлээгүй, сонгуулийн үйл ажиллагаанд зарцуулсан нь АНСДИТХСТ хуулийн 53 дугаар зүйлийн 53.4 “Хандив өгч байгаа иргэн, хуулийн этгээд нь нэр, иргэний бүртгэлийн дугаар болон эх үүсвэрийн талаарх мэдээллээ банкны гүйлгээний баримтад тусгах бөгөөд энэ шаардлагыг хангаагүй хандивыг хандив хүлээн авагч буцаан шилжүүлнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

Хуульд заасны дагуу банкны гүйлгээнд мэдээлэл бүрэн тусгаагүй нийт 1,001.0 мянган төгрөгийн хандивыг хүлээн авч зарцуулсан нэр дэвшигч нарт “Зөрчлийг хянан шийдвэрлэх тухай хууль”-ийн 6.12-т заасны дагуу холбогдох арга хэмжээ авч ажиллах талаар аймгийн Татварын хэлтэс-д албан бичиг хүргүүлэхээр шийдвэрлэв.

Хүснэгт №2. Хандивлагчийн нэр, бүртгэлийн дугаар, эх үүсвэр тодорхойгүй хандивын зарцуулалт (мянган төгрөгөөр)

№	Нам, нэр дэвшигч	Иргэн			
		Тоо	Хандивын дүн	Буцаасан дүн	Зарцуулсан дүн
1	Сайхандулаан сумын МАН-аас нэр дэвшигч	2	1,001.0	-	1,001.0
	<b>Дүн</b>	<b>2</b>	<b>1,001.0</b>	<b>-</b>	<b>1,001.0</b>

Мөн дээрх зөрчил нь Зөрчлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.21 дэх заалтыг зөрчсөн байна.

Харин Айраг сумын Ардчилсан намаас нэр дэвшигч нь 3 иргэнээс ирүүлсэн 150.0 мянган төгрөгийн хандивыг гүйлгээний баримтад мэдээлэл дутуу ирүүлсэн тул буцаан шилжүүлсэн байна.

**БҮЛЭГ 2. НАМ, НЭР ДЭВШИГЧ НЬ БҮРДҮҮЛСЭН ХӨРӨНГИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛЖ, ЗАРДЛЫН ДЭЭД ХЭМЖЭЭГ БАРИМТЛАН АЖИЛЛАСАН БАЙНА.**

**2.1 Бүрдүүлсэн хандив болон хөрөнгийг хуульд заасан зориулалтын дагуу зарцуулсан байна.**

АНСДИТХС-ийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1-т “нам, эвсэл болон нэр

*дэвшигчийг сонгуульд оролцуулахаар бүртгэсэн өдрөөс эхэлж, сонгуулийн зардлын тайлан гаргах өдрийг дуусах хүртэл хугацаанд энэ хуулийн 38.2-т заасан арга хэлбэрээр сонгуулийн сурталчилгаа явуулах зориулалтаар сонгуулийн зардлын данснаас дансанд шилжүүлэх хэлбэрээр зарлага гаргаж болно” гэж заасан байна.*

Дээрх заалтын дагуу сонгуулийн сурталчилгаанд зарцуулсан хөрөнгийг зөвхөн данснаас дансанд шилжүүлэх хэлбэрээр зарцуулсан байна.

Орон нутгийн ИТХ-ын 2025 оны нөхөн сонгуульд 2 нам 6 нэр дэвшигчээс Айраг суманд 6,102.8 мянган төгрөг, Дэлгэрэх суманд 1,995.0 мянган төгрөг, Сайхандулаан суманд 2,096.3 мянган төгрөгийг тус тус зарцуулжээ.

*Хүснэгт №3 Нам, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын ангилал*

№	Зардлын ангилал	Дүн, мянган төгрөг
<b>Монгол ардын нам</b>		
1	Ухуулах байрны түрээсийн зардал	1,200.0
2	Нэр дэвшигчээс зарцуулах хөлс, урамшууллын зардал	3,897.8
3	Сонгуулийн сурталчилгаанд зарцуулах бусад зардал	1,095.0
4	Өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд материал нийтлүүлэх зардал	2,792.0
5	Бусад зардал /аудитын төлбөр, хоол, хүнс, банкны шимтгэл/	108.5
<b>ДҮН</b>		<b>9,093.30</b>
<b>Ардчилсан нам</b>		
1	Нэр дэвшигчээс зарцуулах хөлс, урамшууллын зардал	100.0
2	Сонгуулийн сурталчилгаанд зарцуулах бусад зардал	999.8
3	Бусад зардал /аудитын төлбөр, хоол, хүнс, банкны шимтгэл/	1.1
<b>ДҮН</b>		<b>1,100.85</b>
<b>Нийт дүн</b>		<b>10,194.15</b>

Нийт зардлын 39.2 хувийг нэр дэвшигчээс зарцуулах хөлс, урамшууллын зардалд, 27.4 хувийг өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд материал нийтлүүлэх зардалд, 20.5 хувийг сонгуулийн сурталчилгаанд зарцуулах бусад зардалд, 11.8 хувийг ухуулах байрны түрээсийн зардалд, 1.1 хувийг бусад зардалд зарцуулсан байна.

**2.2 Нэр дэвшигч нар сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, ухуулагч нарын урамшууллын зардлыг анхан шатны баримтгүй зарцуулсан байна.**

АНСДИТХСТ хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1-т "нам, эвсэл болон нэр дэвшигчийг сонгуульд оролцуулахаар бүртгэсэн өдрөөс эхэлж, сонгуулийн зардлын тайлан гаргах өдрийг дуусах хүртэл хугацаанд энэ хуулийн 38.2-т заасан арга хэлбэрээр сонгуулийн сурталчилгаа явуулах зориулалтаар сонгуулийн зардлын данснаас дансанд шилжүүлэх хэлбэрээр зарлага гаргаж болно” гэж заасан.

Орон нутгийн нөхөн сонгуульд оролцсон 2 нам, 6 нэр дэвшигчдэд нийт 10,194.2

мянган төгрөгийн зардлыг зарцуулсан байна. Нэр дэвшигчээс зарцуулах хөлс, урамшууллын зардалд МАН-ын нэр дэвшигчдээс иргэдтэй байгуулсан гэрээний дагуу холбогдох татварыг суутгалгүй олгосон 1,100.0 мянган төгрөг байна

Хүснэгт №4. Татвар суутгаагүй олгосон зардлын хэмжээ

(мянган төгрөгөөр)

№	Нэр дэвшүүлсэн нам эвслийн нэр	Сумын нэр	Нэр дэвшигчээс зарцуулах хөлс, урамшууллын зардал
1	Монгол ардын нам	Айраг сум	400.0
		Дэлгэрэх сум	700.0
<b>НИЙТ ДҮН</b>			<b>1,100.0</b>

Дээрх нэр дэвшигчдээс хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1, 25.6-д заасан арга хэмжээг авч шийдвэрлүүлэх тухай саналыг аймгийн Татварын хэлтэст хүргүүллээ.

**2.3 Төрийн аудитын газраас тогтоосон зардлын дээд хэмжээг баримталж ажилласан байна.**

АНСДИТХСТ хуулийн 49.1-т “Энэ хуульд нийцүүлэн төрийн аудитын орон нутгийн үндэслэн Төрийн аудитын газраас орон нутгийн сонгуульд нам, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоож, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторовын 2024 оны А/28 дугаар тушаалаар баталж, нийтэд мэдээлсэн.

Дээрх тушаалаар аймаг болон сумын ИТХ-ын сонгуульд зарцуулах зардлын хэмжээ болон сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчийн зарцуулсан зардлыг дараах хүснэгтэд тусгав.

Хүснэгт №5 Нам, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын хэмжээ,

(/мянган төгрөг)

№	Нэр	Сумын ИТХ	
		ТАГ-аас тогтоосон дээд хэмжээ	Зарцуулсан хэмжээ
1	Монгол ардын нам	16,000.0-36,000.0	9,093.3
2	Ардчилсан нам	16,000.0-36,000.0	1,100.8

Орон нутгийн ИТХ-ын нөхөн сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчид ТАГ-аас тогтоосон зардлын дээд хэмжээг баримтлан зориулалтын дагуу зарцуулсан байна.

## АУДИТЫН ДҮГНЭЛТ

Орон нутгийн 2025 оны ИТХ-ын нөхөн сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланд хийсэн аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өгч байна. Үүнд:

1. Орон нутгийн 2025 оны хурлын нөхөн сонгуульд Айраг, Дэлгэрэх, Сайхандулаан сумдын Ардчилсан нам, Монгол ардын намаас нийт 6 нэр дэвшигч оролцсон.
2. АНСДИТХСТ хуулийн 56 дугаар зүйлийн 56.5-т заасны дагуу нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын дансны хуулгыг хуулийн хугацаанд харилцагч банкнууд бүрэн ирүүлсэн байна.
3. Айраг сумын Ардчилсан намаас оролцсон 1 нэр дэвшигч нь нэр, иргэний бүртгэлийн дугаар болон хандивын эх үүсвэрийн талаарх мэдээллээ банкны гүйлгээний баримтад бүрэн тусгаагүй иргэдийн 150.0 төгрөгийн хандивыг буцаан шилжүүлсэн байна.
4. Сайхандулаан сумын МАН-ын нэр дэвшигч нь хандивын эх үүсвэр, регистрийн дугаар тодорхойгүй 2 иргэнээс өгсөн 1,001.0 мянган төгрөгийг хууль, журмын дагуу буцаан шилжүүлээгүй зарцуулсан байна.
5. Орон нутгийн ИТХ-ын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон нам, нэр дэвшигч 10,193.0 мянган төгрөгийн хандив, 1.1 мянган төгрөгийг өөрийн хөрөнгөөс гаргаж зардлын санхүүжилтийг бүрдүүлж, 10,194.1 мянган төгрөгийн зардлыг сонгуулийн үйл ажиллагаанд зарцуулсан байна.
6. Нам, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын санхүүжилт, түүний зарцуулалтын тайлангаар нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн 4 иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээд байхгүй байна.

**ХЯНАСАН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.ГАН-ӨЛЗИЙ  
АУДИТЫН МЕНЕЖЕР У.ОЮУНТҮЛХҮҮР  
АХЛАХ АУДИТОР М.ДҮҮРЭНЖАРГАЛ

**АУДИТЫГ ГҮЙЦЭТГЭСЭН БАГИЙН ГИШҮҮД :**

АУДИТОР:  Н.ТҮВШИНБААТАР  
АУДИТОР: Г.МӨНХ-ОРГИЛ